



АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 5/18

Улаанбаатар хот

3.Цогтсайхан, Д.Бэхбат, Д.Нямсүрэн нарт
сахилгын шийтгэл ногдуулах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1.2 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалт, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.3.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн тусгай албаны ажилтан Д.Баасансүрэнгийн гаргасан мэдээллийн дагуу Архивын ерөнхий газрын Санхүү, аж ахуйн хэлтсийн цахилгаанчин 3.Цогтсайхан, лифт, агааржуулалтын систем хариуцсан ажилтан Д.Бэхбат, слесарь Д.Нямсүрэн нарт ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэсэн тул Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 8.2-ын 8.2.1 дэх заалтыг үндэслэн үндсэн цалинг 1 сарын хугацаанд 20 хувиар бууруулсугай.

2. Дээрх зөрчлийг давтан гаргасан тохиолдолд дараагийн шатны сахилгын арга хэмжээ авахыг 3.Цогтсайхан, Д.Бэхбат, Д.Нямсүрэн нарт сануулсугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын газрын даргын үүргийг түр хавсран гүйцэтгэгч Ч.Оюунчимэгт даалгасугай.

ДАРГА

Д.ХОРОЛДАМБА